



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

ОРОН НУТГИЙН САНГУУДЫН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

2024 оны 10
дугаар сар

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ ТУСГАЙ САНГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Айнур

Утас: 94159291 Цахим хаяг: ainurm@audit.gov.mn

Аудитор: Р.Баярмаа

Утас: 99265539 Цахим хаяг: Bayarmaar@audit.gov.mn

2024 он

АГУУЛГА

АГУУЛГА	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товч	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
А.ЗАМЫН САНГИЙН ТӨСВИЙГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ХОЛБОГДОХ ЖУРМЫГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА	7
А.1.Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийг урьд оны гүйцэтгэлийг харгалзан төлөвлөсөн байна	7
А.2. Орлогын давсан хэсгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийг нэмэгдүүлэхэд хуваарилсан байна	7
А.3.Орон нутгийн замын сангийн хөрөнгийг төлөвлөхдөө холбогдох журмыг баримтлаагүй байна	9
Б.САНГУУДЫН ХӨРӨНГИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА	11
Б.1.Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийн зарим хэсгийг үр ашиггүй арга хэмжээнд зарцуулсан байна	11
Б.2.Орон нутгийн төсвийн орлогын давсан хэсгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөд хуваарилсан байна	13
Б.3.Замын санд авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна	14
Б.4. Замын сангийн хөрөнгийн 70.0-87.1 хувийг шууд гэрээгээр жижиг төсөл арга хэмжээнд зарцуулсан байна	14
В. ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАНГ БАРИМТЖУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	16
В.1. Замын сангийн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлсэн байна	16
В.2. Шилэн дансанд “Замын сан” цэс нээлгээгүйгээс мэдээллийг байршуулах боломжгүй байна	17
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	18
ДҮГНЭЛТ:	19
1.Орон нутгийн замын сангийн хөрөнгийг төлөвлөхдөө холбогдох журмыг баримтлаагүй байна	19
ЗӨВЛӨМЖ:	19

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дэд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн төлөвлөгөө, гүйцэтгэл	7
Хүснэгт 2	Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл	8
Хүснэгт 3	Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт	11
Хүснэгт 4	Аймгийн татварын орлогын 2022 оны гүйцэтгэл	13
Хүснэгт 5	Суурь орлогын төлөвлөлт /өмнөх онтой харьцуулахад/	14
Хүснэгт 6	Аймгийн татварын орлогын 2023 оны гүйцэтгэл	14
Хүснэгт 7	Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татварын төлөвлөгөө, гүйцэтгэл	15
Хүснэгт 8	Замын сангийн гүйцэтгэл	15

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд уг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/100, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутагт хэрэгжиж буй тусгай сангуудын үйл ажиллагааны үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг Аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутагт хэрэгжиж буй тусгай сангуудын төсвийг үндэслэлтэй төлөвлөж, холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулсан эсэх
- Орон нутагт хэрэгжиж буй тусгай сангуудын хэрэгжилт үр дүнтэй, холбогдох дүрэм журамд нийцүүлэн зарцуулсан эсэх
- Орон нутгийн тусгай сангуудын хэрэгжилт төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх

Аудитын хамарсан хүрээ

Орон нутагт хэрэгжиж буй тусгай сангуудын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч тэдгээрийн харьяа байгууллагууд Аймгийн Засаг даргын тамгын газар, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Айнур, аудитор Р.Баярмаа нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2024 оны 08 дугаар сарын 14-нээс 09 дүгээр сарын 18-ны хооронд, тайлагналын үе шатны ажлыг 09 дүгээр сарын 19-27-ны хооронд хийж гүйцэтгэв. Аудитын тайланг ҮАГ-ын Аудитын зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

А.ЗАМЫН САНГИЙН ТӨСВИЙГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ХОЛБОГДОХ ЖУРМЫГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

А.1.Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийг урьд оны гүйцэтгэлийг харгалзан төлөвлөсөн байна

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 51 дүгээр тогтоолоор аймгийн ЗДТГ-ын төсвийг 2,923.8 сая төгрөгөөр баталсны дотор аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөд 1,099.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 93 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг анх баталснаас 145.0 сая төгрөгөөр буруулж, 954.4 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 132 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-ын төсвийг 2,830.7 сая төгрөгөөр баталсны дотор Засаг даргын нөөц хөрөнгөд 377.6 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 192 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийг анх баталснаас 192.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 570.0 сая төгрөгөөр тодотгосон байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 197 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийг 20.0 сая төгрөгөөр бууруулан 550.0 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Хүснэгт №1 Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн төлөвлөгөө, гүйцэтгэл
/сая төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	Тайлант он		
	2021	2022	2023
төлөвлөгөө	620.1	954.4	550.0
гүйцэтгэл	618.9	895.3	549.6
зөрүү	(1.2)	(59.1)	(0.4)

Эх сурвалж: Засаг даргын нөөц хөрөнгийн төсөвт хийсэн аудитын судалгаа

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2022 оны батлагдсан төсвийг 2021 оны төлөвлөгөөтэй харьцуулахад 334.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөжээ. Энэ нь 2022 онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөд короно вирусын халдварт өвчний дэгдэлттэй холбоотой гамшгаас хамгаалах зардалд 519.2 сая төгрөгийг нэмж төлөвлөсөнтэй холбоотой байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийг 2023 онд өмнөх оноос 404.4 төгрөгөөр бууруулан баталжээ. Үүнээс үзэхэд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг урьд оны төлөвлөгөө, гүйцэтгэлийг үндэслэж төлөвлөж ирсэн байна.

А.2. Орлогын давсан хэсгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийг нэмэгдүүлэхэд хуваарилсан байна

Аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 2021-2023 оноор авч үзвэл дараах байдалтай байна Үүнд:

Хүснэгт №2 Орон нутгийн суурь орлогын гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	Тайлант он		
	2021	2022	2023
төлөвлөгөө	12,059.3	16,193.6	20,620.4
гүйцэтгэл	13,404.8	16,749.3	20,911.2
зөрүү	1,345.5	555.7	290.8
биелэлтийн хувь	111.2	103.4	101.4

Эх сурвалж: Аймгийн Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын судалгаа

Орон нутгийн 2022 оны орлогын биелэлтийн талаар:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны “Аймгийн 2022 оны төсвийг батлах тухай” 51 дүгээр тогтоолоор орон нутгийн суурь орлогын төлөвлөгөөг 14,941.7 сая төгрөгөөр баталж, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 93 дугаар тогтоолоор орон нутгийн суурь орлогын төлөвлөгөөг 205.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 15,147.2 сая төгрөгөөр баталсан байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлж баталсан дүнг оруулж тооцоход аймгийн суурь орлогын төлөвлөгөөг 1,046.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 16,193.6 сая төгрөгөөр баталсан байна. Аймгийн татварын орлогоос гүйцэтгэлээр 2,809.6 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 333.6 сая төгрөгөөр буюу 13.5 хувиар давуулан биелүүлжээ.

Хүснэгт №4 Аймгийн орон нутгийн суурь орлогын 2022 оны гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2022 оны төсвийн орлогын			
	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Аймгийн төсөвт орох орлого	2,476.0	2,809.6	333.6	113.5

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны орон нутгийн орлогын давсан хэсгийг хуваарилсан талаар ИТХ-ын тогтоол гараагүй байна.

Орон нутгийн 2023 оны орлогын биелэлтийн талаар:

Аймгийн ИТХ-ын 2022 оны “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 132 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөг 17,536.6 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 192 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогын төлөвлөгөөг анх баталснаас 1,195.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 18,732.2 сая төгрөгөөр, Аймгийн ИТХ-ын 2023 оны 197 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогын татварын бус орлогыг 428.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 19,160.6 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумын ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлж баталсан төсвийг оруулж тооцоход аймгийн суурь орлогын 2023 оны төлөвлөгөө 20,620.4 сая төгрөг байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулахад 4,426.7 сая төгрөгөөр нэмэгдэж, үүнээс аймгийн төсөвт орох орлого 245.0 сая төгрөгөөр буурсан байна.

Аймгийн орон нутгийн суурь орлогоос 2023 онд 3063.7 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөөг 832.7 сая төгрөгөөр буюу 37.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №5 Аймгийн орон нутгийн суурь орлогын 2023 оны гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 оны төсвийн орлогын			
	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Аймгийн төсөвт орох орлого	2,231.0	3,063.7	832.7	137.3

Эх сурвалж. Аймгийн Засаг даргын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн орлогын давсан хэсгийн 832.7 сая төгрөгийг 2024 оны 06 сарын 07-ны өдрийн “Аймгийн 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 257 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг нэмэгдүүлэхэд хуваарилсан байна.

А.3.Орон нутгийн замын сангийн хөрөнгийг төлөвлөхдөө холбогдох журмыг баримтлаагүй байна

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 51 дүгээр тогтоолоор Орон нутгийн Замын сангийн нийт төсвийг 639.1 сая төгрөгөөр баталж, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 93 дугаар тогтоолоор Замын сангийн төсөвт өөрчлөлт оруулаагүй, анх баталсан 639.1 сая төгрөгөөр хэвээр нь баталсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 132 дугаар тогтоолоор Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсвийг нийт 1,153.7 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны “Аймгийн 2023 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай” 192, 197 дугаар тогтоолоор Замын сангийн төсөвт өөрчлөлт оруулаагүй 1,153.7 сая төгрөгөөр хэвээр нь баталсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор Замын сангийн 2022, 2023 оны төсвийг батлахдаа төсөл арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар батлаагүй, төсвийг нийт дүнгээр баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т “Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална”, 33.2.6-д “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/416 дугаар захирамжаар Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 28 төсөл арга хэмжээний жагсаалтыг 541.5 сая төгрөгөөр, бусад нэг төсөл арга хэмжээнд 97.6 сая төгрөгөөр нийт 639.1 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А/288 дугаар захирамжаар Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 29 төсөл арга хэмжээний жагсаалтыг 755.8 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 6 дугаар сараас 12 дугаар сард 389.2 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 24 захирамжийг тухай бүр гаргаж, захирамжийн хавсралтад төсөл арга хэмжээний нэр, хэрэгжих хугацаа, төсөвт өртөг, санхүүжих дүнг тусгасан байна.

Замын сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжих 4 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 25 төсөл арга хэмжээг шууд гэрээгээр, 2023 онд хэрэгжих 6 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 23 төсөл арга хэмжээг шууд гэрээгээр худалдан авахаар төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Замын сангийн хөрөнгөөр 2022 онд шууд гэрээгээр гүйцэтгүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг tender.gov.mn сайтад мэдээлээгүй, 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг мэдээлсэн байна.

Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 3.1-д “Авто замын сангийн хөрөнгийг Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус зориулалтын дагуу зарцуулна”, 3.3-д “гэнэтийн хүчин зүйл буюу байгалийн гамшигт үзэгдэл, осол болсны улмаас авто зам, зам байгууламжид эвдрэл, гэмтэл үүссэний улмаас автозамын хөдөлгөөний хэвийн үргэлжлэх боломжгүй болсон тохиолдолд сэргээн засварлахад шаардагдах зардлыг авто замын сангийн тухайн жилийн төсвөөс тэргүүн ээлжид санхүүжүүлнэ” гэж заасан.

Сумын засаг дарга нараас гэнэтийн хүчин зүйлсийн улмаас авто зам, замын байгууламжид гарсан эвдрэл, гэмтлийг засварлуулах талаар аймгийн Засаг даргад 2022 онд 3 санал, 2023 онд 5 санал ирүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар замын сангийн хөрөнгөөр 2022 онд 33, 2023 онд 48 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан боловч эдгээр ажлуудад санал аваагүй, энэхүү зам, гүүрийн ажлууд нь зайлшгүй засвар хийх шаардлагатай байсан эсэх талаар нотлох баримт байхгүй байна.

Мөн Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөвт өртөг, техник эдийн засгийн үндэслэлийг төлөвлөлтийн шатанд боловсруулсан талаар нотлох баримт байхгүй байна.

Төсөл арга хэмжээний жагсаалт батлагдсаны дараа компаниудаас ирүүлсэн гэрээгээр ажил гүйцэтгэх саналыг үндэслэн аймгийн Засаг дарга гэрээ хийхийг санал болгож, цохолт хийж байжээ.

Аж ахуйн нэгжүүдээс аймгийн Засаг даргад Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих ажлуудыг гүйцэтгэх талаар 2022 онд 14, 2023 онд 42 санал хүсэлтийг албан бичгээр ирүүлсэн байна. Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст шууд худалдан авалт хийх замаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан талаар хийсэн хурлын тэмдэглэл, баримт материал байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.4 дэхь заалт, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.2-т “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр

хэрэгжүүлэх их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төслүүд нь төсвийн хөрөнгө оруулалтаар зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай нь холбогдох нотлох баримтаар тогтоогдсон төсөл байх бөгөөд энэ журамд зааснаар төлөвлөнө”, 3.1.4.3-т “хэрэгцээ шаардлага, үндэслэл”, 3.2.3.1-д “шаардлагатай тохиолдолд урсгал зардлыг тооцсон байх”, 3.2.3.3-т “холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх” заалттай нийцэхгүй байна.

Замын сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх 447.4 сая төгрөгийн өртөгтэй 25 төсөл арга хэмжээг 3.5-19.0 сая төгрөгөөр, 2023 онд 1,145.0 сая төгрөгийн өртөгтэй 47 төсөл арга хэмжээг 8.0-20.0 сая төгрөгөөр гэрээ шууд байгуулах замаар гүйцэтгүүлэхээр төлөвлөжээ.

Гүүрний засвар, гүүрний далан байгуулах, голын мөс цэвэрлэх, хаваржаа, зуслангийн замын засвар, давааны замын засвар зэрэг ажлуудыг гэрээ шууд байгуулах замаар гүйцэтгүүлж ирсэн байна.

Замын сангийн жилийн төсөвтэй харьцуулж үзэхэд 2022 онд нийт төсвийн 87.1 хувийг, 2023 онд нийт төсвийн 70.0 хувийг гэрээ шууд байгуулах замаар гүйцэтгүүлэхээр төсөвт өртөг бага жижиг зам засварын арга хэмжээнүүдэд төлөвлөсөн нь Замын сангийн хөрөнгийг үр ашиг багатай хөрөнгө оруулалтад төлөвлөсөн гэж үзэх үндэстэй юм.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, тайлагнах журам”-ыг баримталж үр ашигтай төсөл арга хэмжээнд төлөвлөж зарцуулахыг аймгийн Засаг даргад зөвлөмж болголоо.

Б.САНГУУДЫН ХӨРӨНГИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА

Б.1.Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийн зарим хэсгийг үр ашиггүй арга хэмжээнд зарцуулсан байна

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийн гүйцэтгэлээр 2022 онд 895.3 сая төгрөгийг, 2023 онд 549.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан “аймгийн чиг үүрэг”-т нийцсэн эсэхийг шалгаж үзэхэд дараах байдалтай байна.

График №1



Эх сурвалж: Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад хийсэн судалгаа

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2022 оны төсвийн 21.1 хувийг буюу 191.7 сая төгрөгийг журмын 2.1.1 “хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах” зардалд, 34.5 хувийг буюу 309.6 сая төгрөгийг журмын 2.1.4 “байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх”-д, 39.0 хувийг буюу 349.3 сая төгрөгийг журмын 2.1.5 “энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ”-нд, 4.9 хувийг буюу 44.6 сая төгрөгийг журмын 2.1.6 “шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг”-т зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн 2023 оны төсвийн 24.1 хувийг буюу 132.7 сая төгрөгийг журмын 2.1.1-д заасан арга хэмжээнд, 21.5 хувийг буюу 118.3 сая төгрөгийг журмын 2.1.4 “байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх”-д, 40.5 хувийг буюу 222.5 сая төгрөгийг журмын 2.1.5 “энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ”-нд, 13.9 хувийг буюу 76.1 сая төгрөгийг журмын 2.1.6 “шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг”-т тус тус зарцуулжээ.

“Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4-т “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг зарцуулах ба хохиролд зарцуулагдаагүй

үлдэгдлийг сарын хуваариас тооцоолж Засаг даргын нөөцөд бэлэн байршуулсан байна” гэж заасан.

Хэрэгжилтийг нь шалгаж үзэхэд Засаг даргын нөөц хөрөнгийн нийт төсвийн 2022 онд 21.4 хувийг, 2023 онд 24.1 хувийг журмын 3.4-т заасан чиглэлээр зарцуулсан бөгөөд 2022 онд 35.1 сая төгрөгийг, 2023 онд 22.9 сая төгрөгийг дансны үлдэгдэлд бэлэн байлгах ёстой боловч дээрх заалтыг зөрчиж зориулалт бус зардалд хуваарилж зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн нийт төсвийн зарцуулалтад дүгнэлт хийж үзэхэд 2022 онд төсвийн 34.6 хувийг, 2023 онд 21.5 хувийг байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэхэд, 2022 онд 39.0 хувийг, 2023 онд 40.5 хувийг төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд зарцуулсан нь нөөц хөрөнгийн дийлэнх хэсгийг үр ашиггүй зардалд зарцуулсан гэж үзэх үндэстэй байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн эсэхийг шалгаж үзэхэд анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй, журмын 6.1-д “Нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй албан байгууллагуудын хүсэлтээр олгосон хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаж ирүүлээгүй, баримтжуулаагүй байна. Тухайлбал: 199.3 сая төгрөгийн баримт материалыг аудитын явцад тухайн байгууллагуудаас авхуулж, зөрчлийг арилгаж ажилласан ба 2022 онд олгосон 67.0 сая төгрөгийн, 2023 онд олгосон 85.4 сая төгрөгийн хөрөнгийн зарцуулалтыг хянаж, анхан шатны баримтыг бүрдүүлж баримтжуулаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх, журмыг мөрдөн ажиллах талаар албан шаардлага өгөв.

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйл, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.2-т “урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх” гэснийг зөрчиж 2022 онд 4.0 сая төгрөгийг, 2023 онд 7.6 сая төгрөгийг төсөвт байгууллагуудад тоног төхөөрөмж авах, урсгал зардлыг санхүүжүүлэх, кассаас бүрдэл дутуу баримтаар зарцуулсан зөрчилд албан шаардлага өгч, 2022 онд аймгийн Засаг даргын албаны машины урсгал засварт 6.0 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Аудитын дүнгээр байгууллагуудын төсвийн хөрөнгөөр шийдэх боломжтой зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахгүй байх, нөөц хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй, үр ашигтай арга хэмжээнд зарцуулахыг Аймгийн Засаг даргад зөвлөмж болголоо.

Б.2.Орон нутгийн төсвийн орлогын давсан хэсгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөд хуваарилсан байна

Аймгийн төсөвт орох орон нутгийн суурь орлогоос 2022 оны гүйцэтгэлээр 2,809.6 сая төгрөгийг оруулж, орлогын төлөвлөгөөг 13.5 хувиар буюу 333.6 сая төгрөгөөр, 2023 онд 3063.7 сая төгрөгийг оруулж, орлогын төлөвлөгөөг 37.3 хувиар буюу 832.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр тус аймгийн орон нутгийн суурь зарлагыг анх баталснаас 7,344.4 сая төгрөгөөр

бууруулж баталснаас Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2022 оны орон нутгийн орлогын давсан хэсгийг дахин хуваарилсан талаар тогтоол гараагүй.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 06 сарын 07-ны өдрийн “Аймгийн 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 257 дугаар тогтоолоор орлогын давсан хэсгийн 832.7 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг нэмэгдүүлэхэд хуваарилсан байна.

Б.3.Замын санд авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна

Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 2.1-д “... нийслэл, орон нутгийн авто замын сан нь Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ”, 2.2-т “Авто замын сангийн тухайн жилийн төсвийг Төсвийн тухай хууль тогтоомж, түүнтэй холбогдсон журмын дагуу боловсруулна”,

2.5-д “Нийслэл, орон нутгийн авто замын санд дараах байдлаар хөрөнгө төвлөрүүлнэ”, 2.5.1-д “авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг аймаг, дүүргийн татварын албанаас тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд” гэж заасан байна.

Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогоос 2022 онд 577.4 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 77.4 сая төгрөгөөр, 2023 онд, 696.9 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 96.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвараас 2022 онд 577.4 сая төгрөгийн орлого оруулж, Замын санд 542.9 сая төгрөгийг төвлөрүүлж, 34.5 сая төгрөгийг дутуу оруулжээ.

2023 онд 696.9 сая төгрөгийн орлого оруулж, Замын санд 1,153.7 сая төгрөг оруулж, 456.8 сая төгрөгийг илүү төвлөрүүлжээ. Энэ нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийн орлогоос Замын санд 456.8 сая төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Торгуулийн орлогоос 2022 оны орсон 515.2 сая төгрөгийн орлогоос “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 2.5.4-д заасны дагуу Замын санд ногдох хэсгийг төвлөрүүлээгүй байна.

Б.4. Замын сангийн хөрөнгийн 70.0-87.1 хувийг шууд гэрээгээр жижиг төсөл арга хэмжээнд зарцуулсан байна

Замын сангийн хөрөнгөөр 2022 онд 36, 2023 онд 53 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн Засаг даргын захирамж гарсан байна. Үүнээс: 2022 онд 5 төсөл арга хэмжээ, 2023 онд 9 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Тухайлбал: 2022 онд төлөвлөсөн ажлуудаас 3 төсөл арга хэмжээ буюу Дэлүүн сумын Төгрөгийн замын засвар, тус сумын 1 дүгээр багийн Хар говийн замын засвар, Буянт сумын Өмнөголын доод талын замын засварын ажил,

2023 онд Дэлүүн сумын 8 дугаар багийн Ноорт Хөх үзүүрийн зам, Толбо сумын 5 дугаар багийн зам, Бугат сумын Хатуугийн эхийн замын засвар, Алтай таван богд чиглэлийн аяллын бүсийн замд тэмдэг тавих ажил, Өлгий сумын 8 дугаар багийн 1 дүгээр хэсгийн гэр хорооллын гудамжны замын засвар, Цагааннуур боомтын хойд талын замын өргөтгөл, Шар нуурын постоос Өлгий орох чиглэлд түр зам гаргах, Өлгий сумын төвийн хатуу хучилттай авто замуудад хурд сааруулагч тавих ажил, Өлгий сумын 4 дүгээр багийн Цахилгаан шугам сүлжээний газрын урьд талын 1, 3 дугаар гудамжны замын засварын ажлууд хийгдээгүй байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн 2022 онд 28.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 2 ажил, 2023 онд 38.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3 ажлыг хэрэгжүүлж ашиглалтад хүлээн авсан байна.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 2022 онд шинээр хэрэгжих 31 төсөл арга хэмжээг 587.1 сая төгрөгөөр, 2023 онд шинээр хэрэгжих 34 төсөл арга хэмжээг 876.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, цас арилгах, зам нээх, арга хэмжээ зохион байгуулах зэрэг 6 ажлын зардлыг сумдын ЗДТГ, байгууллага, компанид олгосон байна.

2022 онд 4 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулах тендер шалгаруулалтаар сонгож, 146.7 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ хийж, 27 төсөл арга хэмжээг 440.4 сая төгрөгөөр гэрээ шууд байгуулах замаар, 2023 онд шинээр хэрэгжих 6 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг тендер шалгаруулалтаар сонгож, 28 төсөл арга хэмжээг 531.5 сая төгрөгөөр гэрээ шууд байгуулах замаар хэрэгжүүлсэн байна.

Замын сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 552.3 сая төгрөгийн 29 төсөл арга хэмжээний худалдан авалтын ажлыг 6 дугаар сарын 08-наас 9 дүгээр сарын 22-ны хооронд, 2023 оны 697.5 сая төгрөгийн худалдан авалтын ажлыг 2023 оны 06 дугаар сарын 05-наас 12 дугаар сарын 11-ний хооронд зохион байгуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг зөрчсөн тул албан шаардлага өгөгдлөө.

2022 онд шинээр хэрэгжүүлэх 31 төсөл арга хэмжээний нь 6 гүүрийн засвар, 23 нь зам засварын, 2023 онд хэрэгжүүлэх 38 төсөл арга хэмжээний 3 гүүрийн засвар, 35 нь зам засварын ажил эзэлж байна.

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2022 оны 1, 2023 оны 2 төсөл арга хэмжээ тайлант онд хэрэгжээгүй, дараа онд шилжсэн.

2022 онд Өлгий нисэх буудлын 15.0 сая төгрөгийн өртөгтэй авто зогсоолын өргөтгөл, 2023 онд 67.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зам засварын хоёр ажил гэрээт хугацаанд дуусаагүй зөрчилд албан шаардлага өгөгдлөө.

Хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийг “Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах комисс”-т хүлээлгэн өгч, 2022 онд 30 төсөл арга хэмжээнд 594.6 сая төгрөгийн, 2023 онд 36 төсөл арга хэмжээнд 889.9 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

2022 онд шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээний нийт төсвийн 87.1 хувийг 3.5-19.0 сая төгрөгөөр, 2023 онд 70.0 хувийг 10.0-20.0 сая төгрөгөөр гэрээ шууд байгуулах замаар олгож, голын мөс цэвэрлэх, далан байгуулах, жалгын замын засвар, хавцлын амны засвар, гудамжны замын засвар, мэдээллийн самбар хийх, авто зогсоол хийх, автозамын нөхөөсний ажил, гүүрийн засвар, зуслангийн замын засвар зэргээр жижиглэн, үр ашиг багатай арга хэмжээнд зарцуулсан байна.

Алтанцөгц сумын Шүүгийн амны гүүрээс сумын төвийн одоо тавигдаж буй зам хүртэлх замын засварын ажил тайлант хугацаанд хэрэгжээгүй байхад хяналтын зардал 370.4 мянган төгрөгийг, Цагааннуур тосгоны гүүрнээс хавцлын ам хүртэлх замын засварын ажил хийгдээгүй байхад 649.6 мянган төгрөгийн урьдчилж олгосныг дараа онд хасаж тооцоо хийх, 2023 оны аймгийн 2,3,4,12,13 дугаар багуудад буусан үерийн гамшгийн үед бусад данснаас зарцуулахаар шийдвэр гарсан 2.9 сая төгрөгийг замын сангийн данснаас “Баян сан зам” ХХК-д анхан шатны баримтгүйгээр шилжүүлсэн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөгдлөө.

“Баян сан зам” ХХК-д нисэх буудлын 2023 онд хэрэгжсэн авто зогсоолын өргөтгөлийн ажлын 271.5 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү олгосныг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

В. ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАНГ БАРИМТЖУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

В.1. Замын сангийн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлсэн байна

Барилга захиалагчийн алба Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу орон нутгийн замын сангаар хэрэгжүүлсэн 62 зам гүүрийн барилга, засварын ажилд тавих захиалагчийн хяналтыг хууль журмын дагуу хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 2022-2023 онд нийт 68 төсөл арга хэмжээ хэрэгжсэний дотор малчдын нүүх замын арчилгаа, давааны замын цас арилгах ажил, замын хөдөлгөөний талаар сургалтын хийх 5 ажлыг Засаг даргын захирамжаар сумдын ЗДТГ-ууд, Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн газар хэрэгжүүлжээ.

Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах ажлын хэсэг нь гишүүний саналын хуудсыг хөтөлж, хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, төсөл арга хэмжээг ашиглалтад авах ажлын хэсгийн акт, дүгнэлтийг үйлдэж хүлээн авсан байна. Барилга захиалагчийн албанаас захиалагчийн нэгдсэн дүгнэлтийг гаргаж, хяналт хийсэн ажлын талаар тухай бүр тайлагнасан байна.

Захиалагч болон гүйцэтгэгч тал гэрээг дүгнэж акт үйлдэн баримтжуулсан байна. Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс Замын сангаас хэрэгжсэн ажлуудын гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс тухай бүр олгосон байна.

Сагсай сумын Рашаантын 45.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй модон гүүр, Өлгий Нисэх буудлын 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй авто зогсоолын өргөтгөл, Өлгий сумын 4 дүгээр багийн үерийн далангаар нэвтрэх 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй автомашины гүүрийг улсын комисс ашиглалтад хүлээн авч, холбогдох байгууллагуудын данс бүртгэлд орлогод авч бүртгэсэн байна. Мөн 2022 онд 68.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Дэлүүн сумын /Хар усны/ Ганц модны модон гүүрийн засварын ажлыг ажлын хэсэг хүлээн авч холбогдох байгууллага нь үндсэн хөрөнгийн өргөтгөл, сайжруулалтаар капиталжуулан бүртгэлд тусгасан байна. 2023 онд замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Өлгий сумын орох гарах 5 чиглэлийн замын уулзварыг камержуулах ажлыг ажлын хэсэг хүлээн авч аймгийн Цагдаагийн газрын бүртгэлд тусгасан байна.

Аудитад авто замын сангийн орлого зарцуулалтыг “Авто замын зөвлөл”-д тайлагнасан эсэх талаар баримт материал ирүүлээгүй байна.

Энэ нь “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам” -ын 4 дэх зүйлд заасныг хангахгүй байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хяналтын улсын ахлах байцаагч 2022 онд замын сангийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн байна. Тус байгууллага татан буугдсанаар авто замын хяналтын улсын ахлах байцаагч 2023 оноос аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т томилогдсон байна. Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамж, аймгийн ЗДТГ-ын даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу 2023 оны авто замын сангийн зарцуулалтад хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасан хугацаанд аудит хийлгэсэн байна.

Тайлант хугацаанд Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналт болон бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Засаг даргын нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг холбогдох журмын дагуу гаргаж хугацаанд нь тайлагнаагүй байна.

Тухайлбал: Засаг даргын нөөц хөрөнгөнөөс төсөвт байгууллагуудад 2022 онд олгосон 67.0 сая төгрөгийн, 2023 онд олгосон 85.4 сая төгрөгийн нийт 152.4 сая төгрөгийн зарцуулалтын тайланг гаргуулан авч санхүүгийн баримтад хавсаргаагүй, анхан шатны баримтын бүрдэлийг хангаагүй, цахим баримтыг бүрдүүлээгүй, хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 6 дахь хэсгийн 6.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Аудитын явцад 2022-2023 онд 13 байгууллагад олгосон 198.3 сая төгрөгийн санхүүжилтийн зарцуулалтын баримт, тайланг тухайн байгууллагуудаас гаргуулан авч шалгаж зөрчлийг арилгуулж ажиллав.

Төсвийн захирагч нь холбогдох байгууллага иргэнээс ирүүлсэн хүсэлт, аливаа үйл ажиллагааны төсөв, тооцооллыг үндэслэж холбогдох баримтад үндэслэн санхүүжилтийг олгодог боловч зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

В.2. Шилэн дансанд “Замын сан” цэс нээлгээгүйгээс мэдээллийг байршуулах боломжгүй байна

Аудитаар Засаг даргын нөөц хөрөнгийн шилэн дансны мэдээллийг шалгаж үзэхэд Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө зарцуулах тухай 2022 онд 182 шийдвэр, 2023 онд 130 шийдвэр гарсныг шилэн дансны цахим мэдээллийн хуудаст мэдээлсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим мэдээллийн санд тус аймгийн “Орон нутгийн замын сан” цэс нээлгээгүйгээс тус сангийн төсөв, хэрэгжсэн төсөл арга хэмжээний талаар мэдээлээгүй байна.

Шилэн дансны цахим мэдээллийн санд “Орон нутгийн замын сан” цэс нээлгэж, мэдээллийг хуулийн дагуу мэдээлж ажиллахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэст зөвлөмж болголоо.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Аудитын тайлангийн төслийг 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 563 дугаар албан бичгээр аймгийн Засаг даргад санал авахаар хүргүүлсэн боловч саналаа ирүүлээгүй болно.



АД 24.10.03, № 563
танай _____ -нм № _____ -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
А.КАМЕЛИЯТ ТАНАА

"Орон нутагт хэрэгжиж буй тусгай сангуудын үйл ажиллагааны үр нөлөө" сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүргүүлж байна.

Аудитын тайлангийн төсөлтэй танилцаж саналаа 10 дугаар сарын 11-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ж.АЙГҮЛ



ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- 1.Орон нутгийн замын сангийн хөрөнгийг төлөвлөхдөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг жагсаалтаар батлаагүй байгаа нь холбогдох журамд нийцээгүй байна
2. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг зарим үр ашиг багатай арга хэмжээнд зарцуулсан нь үндсэн зорилтыг алдагдуулж, ач холбогдлыг бууруулсан байна
3. Замын сангийн хөрөнгийн 80 орчим хувийг жижиг төсөл арга хэмжээнд зарцуулснаас томоохон хөрөнгө оруулалтууд хийгдэх боломжийг хязгаарласан байна
4. Шилэн дансны нэгдсэн цахим мэдээллийн санд “Орон нутгийн замын сан”-гийн төсөв, хэрэгжсэн төсөл арга хэмжээний талаар мэдээлээгүйгээс иргэдийн мэдээллээр хангагдах, ил тод байдал алдагдсан байна.
5. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгаад анхаарч дотоод хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн Засаг дарга /Е.Зангар/-д:

1. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох журмыг баримтлах, хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарах;
2. Засаг даргын нөөц хөрөнгөнөөс байгууллагуудын төсвийн хөрөнгөөр шийдэх боломжтой зардлыг олгохгүй байх, нөөц хөрөнгөнөөс зориулалт бус зардал гаргахгүй байх, нөөц хөрөнгийг үр дүнтэй, үр ашигтай арга хэмжээнд зарцуулах;

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Д.Ансаган/-д:

1. Орон нутгийн тусгай сангуудын төсвийн төлөвлөлт, зарцуулалтад тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх;
2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “Орон нутгийн замын сан” цэс нээлгэж, холбогдох мэдээллийг хугацаандаа ил тод мэдээлж ажиллах;

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т заасан хугацаанд буюу аудитын тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.